

**“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН 2018 ОНЫ
05 ДУГААР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2018.06.05

Нэг. Зорилго

“ГТХЗНТ” УТУГ-ын бүтцийн нэгжүүдийн 2018 оны 05 дугаар сарын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаарх санал, зөвлөмжийг удирдлагад танилцуулах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх зорилготой.

Хоёр. Үндэслэл

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн хяналт-шинжилгээ, үнэлгээний журмыг үндэслэв.

Гурав. Төлөвлөгөөний хэрэгжилт

Хөдөлгөөн зохицуулалт, хөдлөх бүрэлдэхүүний хэлтэс 8, Технологи, мэдээлэл, сургалт, судалгааны хэлтэс 18, Захиргаа, санхүүгийн хэлтэс 27, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд нийт 53 ажлыг төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Нэгжүүдийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд бүрэн хэрэгжсэн 44, хэрэгжих шатанд 8, хэрэгжээгүй 1 арга хэмжээтэй, биелэлт **90,94** хувьтай байна.

№	Нэгжийн нэр	Төлөвлөсөн ажлын тоо	Хэрэгжилтийн байдал /хувиар/					Нэгжийн дүн
			Бүрэн хэрэгжсэн 100 хувь (90-100 хүртэл хувь)	Хэрэгжих шатанд 70 хувь (50-89 хүртэл хувь)	Хэрэгжилт хангалтгүй 30 хувь (10-49 хүртэл хувь)	Хэрэгжээгүй 0 хувь (0-9 хүртэл хувь)	Хэрэгжилт ийг тооцох хугацаа болоогүй	
1	ХЗХБХ	8	7	-	1	-	-	91,25
2	ТМССХ	18	13	4	1	-	-	89,44
3	ЗСХ	27	24	1	1	1	-	91,85
	Дүн	53	44	5	3	1	-	90,94

Дөрөв. Санал зөвлөмж:

Хөдөлгөөн зохицуулалт, хөдлөх бүрэлдэхүүний хэлтэст:

1. Хөдлөх бүрэлдэхүүн бүртгэх, дугаар олгох журмыг шинэчлэн батлуулах арга хэмжээ удаашралтай байгаад анхаарч, ЗТХ-ийн сайдын 2014 оны 234 дүгээр тушаал болон “Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт. 2-р хэсэг. Төмөр замын ачааны вагоны дугаарлалтад тавих шаардлага MNS 6630-2:2016” стандартад нийцүүлэн боловсруулж батлуулах;

2. Суурь бүтэц дэх хөдөлгөөний 2017-2018 оны өвлийн зурмагийн гүйцэтгэлд Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журмын дагуу шинжилгээ хийж, дүгнэлт зөвлөмжийг суурь бүтэц эзэмшигчид хүргүүлэх, ажлын үр дүнг ЗТХЯ-нд танилцуулах арга хэмжээг VI сард төлөвлөж хэрэгжүүлэх;

3. Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2016.11.24-ний өдрийн 56 дугаар тогтоолоор батлагдсан “Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт. 3-р хэсэг “Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтад тавих шаардлага” MNS 6630-3:2016 стандартыг хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч, хамтран ажиллах талаар яамны ХШҮДАГ-т хүргүүлсэн албан бичгийн хариуг лавлах, ЗТХХ-ийн улсын байцаагч нартай очиж уулзах, чиглэл авах, хэрхэн хамтран ажиллах талаар зөвшилцөх;

4. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.05.22-ны өдрийн “Ачааны вагонд нэгдсэн тооллого хийх тухай” 109 дүгээр тушаалыг хэрэгжүүлж, төмөр замын салбарт ашиглагдаж буй гадаад ба дотоод ачааны вагоныг тоолох зааврын дагуу тооллого зохион байгуулах, бэлтгэл ажлыг сайтар базаах;

Технологи, мэдээлэл, сургалт, судалгааны хэлтэст:

1. Төвийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулах ажил нь үр дүнгийн гэрээнд тусгагдсан “...төмөр замын байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгох ...” арга хэмжээтэй шууд холбоотой бөгөөд журмын төсөл, түүний хавсралтаар батлагдах мэдээ мэдээллийн маягтуудыг шинэчлэх, өөрчлөх, сайжруулах ажилд ач холбогдол өгч, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх байгууллагаас ирүүлсэн саналыг үндэслэлтэй гэж үзвэл журмын төсөлд тусгах, ажлын хэсгийн хурлаар эцэслэн хэлэлцүүлэх, төслийг сайдын тушаалаар батлуулах, ХЗДХЯ-нд хүргүүлэх, хянуулах, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхтэй холбоотой баримт бичгийн бүрдэлийг /сайдын тушаалын төсөл, нөлөөллийн шинжилгээ, танилцуулга, журмын төсөл, хурлын тэмдэглэл, саналын нэгтгэл, бусад г.м/ сайтар бүрдүүлж ЗТХЯ-нд хүлээлгэн өгөх;

2. ЗТБХБ-ын сайдын 2010 оны 197 дугаар тушаалаар батлагдсан “Зам, тээврийн салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох нийтлэг дүрэм” болон яамны цахим хуудсанд байршуулан санал авч буй Төмөр замын тээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.14-т заасан “Төмөр замын мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, сургалт явуулах, мэргэжлийн шалгалт авах журам”-ын төсөлд тусгах саналыг салбарын өмнө тулгамдаж байгаа асуудлууд, сургалтын хэрэгцээ шаардлага, зохих судалгаа, нотолгоо, баримтад тулгуурлан үндэслэлтэй боловсруулах, саналыг албан бичгээр буюу албан ёсоор ЗТХЯ-нд хүргүүлж танилцуулах, тусгуулах;

3. Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн, суурь бүтэц, тусгай зөвшөөрөл, статистик мэдээний бүртгэл хөтлөх мэдээллийн сан төвлөрүүлэх тусгай програм хангамжийн ажлын даалгаврын төсөл боловсруулж батлуулсан, түүнчлэн “Интерактив” ХХК, “Эйбл софт” ХХК, “Ритус” ХХК, “Ай Ти Солушинс” ХХК-иас програм хангамж зохиомжлох зардлын төсөл, үнийн санал авсан байсан. Тус арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа “6-7 сар” гэж төлөвлөгдсөн учир холбогдох байгууллагатай байгуулсан гэрээний эрх, үүргийг хангуулах чиглэлээр нэгжийн төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээ тусгаж хэрэгжүүлэх;

4. Төмөр замын тээврийн салбарын мэргэшсэн, зөвлөх инженер, бүтээлүүдээр мэдээллийн сан үүсгэх ажил нь тус хэлтсийн ажлын төлөвлөгөөнд III, IV, V сар дамжин тусгагдаж хэрэгжсэн байна. Иймд салбарын мэргэшсэн, зөвлөх инженер, эрдэмтэн, докторын судалгаа, эрдэм шинжилгээний ажил, бүтээлүүдээр мэдээллийн сан үүсгэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт төвийн Захиралд танилцуулах, чиглэл авах;

5. Тус хэлтсээс хариуцан орчуулж, боловсруулсан ГОСТ 33435-2015, Р 54115-2010, О+Р 941 стандартын орчуулга, боловсруулалттай холбоотой ажлууд тайлант сард төлөвлөгдөөгүй байна. Эдгээр ажлууд ямар шатанд явж байгаа, хэзээ эцэслэн дуусах, холбогдох байгууллагуудаас хэдийд санал авах нь тодорхойгүй байгаа учир 06 дугаар сарын ажлын төлөвлөгөөнд бодитой ажил тусгаж, хэрэгжүүлэх;

6. “ГТХЗНТ-ийн Техник эдийн засгийн үндэслэл, барилгын зураг төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх”, “ЗТХЯ, ГТХЗНТ, Далайн захиргааны албан хаагчдын орон сууц, Төв, ДЗ-ны оффисын барилгын зураг төслийн ажил боловсруулахад захиалагчийн хяналт тавих, барилга угсралтын ажлын гүйцэтгэгч, санхүүжүүлэх банкныг сонгож барилга угсралтын ажлыг эхлүүлэх, шаардлагатай техникийн нөхцөлүүдийг авах, инженер геологийн дүгнэлт

хийлгэх”, “Төмөр замын тээврийн салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох нийтлэг дүрмийг шинэчлэн боловсруулахад ТББ-тай хамтран ажиллах, тус дүрмийн дагуу сургалтыг зохион байгуулж ажиллах” арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, удаашралтай байгаад дүгнэлт хийж ажлаа эрчимжүүлэх;

7. Тэгш байдлын зарчмыг баримталж, ажилтны ажлын ачааллыг жигдрүүлж ажиллах; /мэргэжилтэн Э.Дэлгэрмөрөн, Д.Дарьсүрэн, Н.Номин нар тус бүр 1, мэргэжилтэн Д.Амарзаяа хамтарч 1 ажил төлөвлөсөн бол мэргэжилтэн Э.Анударийн төлөвлөсөн болон биелэлт гаргасан ажлууд ойролцоо, давхардсан утгатай байна.

Захиргаа, санхүүгийн хэлтэст:

1. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмын төслийг эцэслэн боловсруулж дуусгах, нэгжийн дарга нараас санал авах, захирлын тушаалаар батлуулах;

2. ...харьяа байгууллагын тогтмол гаргах тайлан, мэдээллийн нэр төрөл, хугацааны 3.12, 4.12-т заасан “Худалдан авах ажиллагааны тайлан” болон “Байгууллагын ил тод байдлын тайлан”-г 2018.06.25-ны дотор ЗТХЯ-ны холбогдох газарт албан бичгээр хүргэж тайлагнах. Байгууллагын ил тод байдлын тайлан мэдээллийг ТМССХ-тэй хамтран гаргах;

3. Засгийн газрын 2017.12.27-ны өдрийн хуралдааны 56 дугаар тэмдэглэл, ЗТХ-ийн сайдын 2018.01.23-ны 01/355 дугаартай албан бичгийн хүрээнд Засгийн газар, ЗТХ-ийн сайд, төвийн Захирлын “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 2017.10.26-ны өдрийн 01, 2017.11.20-ны өдрийн 02 дугаар албан даалгавар, 2017.11.22-ны өдрийн А/74, 2018.01.02-ны өдрийн А/01 дүгээр тушаалын мөрөөр хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээллийг 2018.06.25-ны дотор ЗТХЯ-ны ТЗУГ-т хүргэж, тайлагнах;

4. Хөдөлмөрийн дотоод журмын 6.2.5-д заасныг хэрэгжүүлж, ажилтны 2018 оны эхний хагас жилд гүйцэтгэсэн ажлын тайлан хамгаалах удирдамж, хуваарийг боловсруулж батлуулж мөрдөх;

5. Ажилтны хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүнг бодитой, үнэн зөв үнэлж дүгнэхэд онцгой анхаарч, үр дүнгийн бодит үнэлгээнд тулгуурлан урамшуулал олгох эсэх асуудлыг захирлын тушаалаар нэг мөр шийдвэрлүүлэх. Ингэхдээ төвийн захирлын 2018 оны А/23 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан хөдөлмөрийн гэрээ дүгнэх шалгуур үзүүлэлтийн дагуу ажил олгогч, ажилтан хооронд байгуулсан хөдөлмөрийн гэрээг хагас жилээр дүгнэх ажлыг хамтад нь хэрэгжүүлэх эсэх асуудлыг удирдлагатай зөвшилцөн шийдвэрлэх;

6. ЗТХ-ийн 2018 оны “Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 05 дугаар тушаалыг хэрэгжүүлж, сайдын тушаалаар өгөгдсөн үүргийн биелэлт, үр дүнг ЗТХЯ-ны ТЗУГ-т танилцуулах;

7. Төрийн болон албаны нууцын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Нууцын баримт бичигтэй ажиллах журмыг хэрэгжүүлэх хүрээнд нууц хамгаалах чиг үүргийг аль нэг ажилтанд давхар хариуцуулах, эрх, үүрэг, хариуцлагыг АБТ-д нэмэлтээр тусгаж баталгаажуулах, нууцын зэрэглэлийн тэмдэглэгээний дардасыг хийлгэх;

8. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг мэдээлж, сурталчлах, Зам, тээврийн салбарт “Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг яамны ТЗУГ-т хүргүүлэх;

9. Төвийн хагас жилийн эд хөрөнгийн тооллого, бүртгэлийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу 06 дугаар сард зохион байгуулах;

Нийтлэг:

1. Ажилтны ажлын цагийн болон албан ажлаар гадуур ажилласан бүртгэл, чөлөө зөвшөөрлийн асуудалд тавих хяналтыг чангатгах, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг мөрдөх, мөрдүүлэх;

2. Нэгжийн дарга нар харьяалах хэлтсийн ажилтнуудын үйл ажиллагаанд тавих хяналт болон ажлын бүтээмж, гүйцэтгэл, үр дүнг сайжруулахад шаардлагатай арга хэмжээг шуурхай шийдвэрлэж, зохион байгуулж ажиллах, сахилга, хариуцлагыг өндөржүүлэх;

3. Үйл ажиллагааны холбогдолтой захирлын баталгаажсан шийдвэр, төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас өгсөн бодлогын чиглэл, зөвлөмж, хугацаатай үүрэг, даалгаврыг нийт ажилтанд танилцуулах, ажлын уялдаа холбоог хангах.

ХЯНАСАН:

“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗАХИРАЛ

Т.АРИУНБААТАР

ЗӨВШӨӨРСӨН:

ХЗХБХ-ИЙН ДАРГА

М.БАТМЯГМАР

ТМССХ-ИЙН ДАРГА

Б.ЭНХЖАРГАЛ

ЗСХ-ИЙН ДАРГА

Н.ШИНЭБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ХШҮДАХА

Э.ОСОРЖАМАА